

**URGENT төслийн хүрээнд Ховд Их Сургууль дээр шинээр боловсруулж буй
“Хотын экологи” цахим хичээлийн хөтөлбөрт санал өгөх тухай**


Б.Энхчимэг миний бие Монгол Улсын Их Сургууль, Хэргэлээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн сургуулийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн Хүрээлэн буй орчны инженерчлэлийн хөтөлбөрт Хотын ложистик, цэвэр энергийн технологи, Инженерийн дүн шинжилгээ болон Хөрсний экологи зэрэг чиглэлүүдээр хичээл заадаг.

URGENT төслийн хүрээнд Ховд Их Сургууль дээр шинээр боловсруулж буй “Хотын экологи” цахим хичээлийн хөтөлбөрт ижил төрлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг их сургуулийн зүгээс дараах саналыг хүргүүлж байна.

Хичээлийн тодорхойлолтоос харахад хичээлийн нэр болон хичээлийн агуулга нь тохирсон гэж үзэж байна. Гэвч уг хичээл нь оруулсан ахисан түвшний оюутуудад зориулсан тул хичээлийн агуулгыг илүү нарийвчлан оруулах саналтай байна. Үүнд:

1. Хотын экологийг судлахад ашигладаг аргууд болох химийн болон биохимийн техник, температурын бичлэг, дулааны зураглалыг зайнаас тандан судлах, экологийн урт хугацааны судалгааны газруудыг хамарч үзэх буюу нэмж оруулах;
2. Хотын экологийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал байдалтай холбон тайлбарласан хичээл нэмэх;
3. Боломжтой бол хими болон зайнаас тандан судлалын лабораторын хичээл оруулж, мэдээ цуглуулах, туршилт хийлгэх, мэдээгээ боловсруулах, үр дүнгээ танилцуулах зэрэг мэдлэг чадваруудыг эзэмшүүлэх зэрэг нэмэлт хичээлүүдийг оруулах саналтай байна.

Хичээлийн төлөвлөгөөнд санал өгсөн:

Ахлах багш  Б.Энхчимэг